



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

19⁹⁷ оны 6 дугаар
сарын 14 өдөр

Дугаар 6.146.

Улаанбаатар
 хот

Улаанбаатар хотын Захирагчийн
харьяа байгууллагуудыг байгуу-
лах, дарга, захирлуудыг томилох
тухай

Нэг. Монгол улсын Засгийн газрын 1997 оны 108 дугаар тогтоолын дагуу
Улаанбаатар хотын Захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд дараах байгууллагуудыг
ажиллуулсугай.

1. Ус сувгийн ашиглалтын газар
2. Хотын тээвэр зохицуулалтын газар
3. Орон сууц, нийтийн аж ахуйн компани
4. Хотын мал эмнэлгийн газар
5. Иргэдэд үйлчлэх "Буян" компани
6. Max, тос бэлтгэлийн компани
7. "Хот тохижилт" компани
8. Гадаадын иргэдэд үйлчлэх "Гэгээ" компани
9. "Зураг төсөл" компани
10. Геодезийн үйлчилгээ компани
11. "Улаанбаатар импэкс" компани
12. Түлшний мод бэлтгэх компани
13. Халаалтын зуухны ашиглалтын төв

Хоёр. Засгийн газрын 1997 оны 108 дугаар тогтоолыг үндэслэн хотын "Гэрэлтүүлэг чимэглэл", "Цэцэрлэгжилт", "Нөөц", "Тохижилт" компаниудыг 1997 оны 6 дугаар сарын 14-нээр тасалбар болгон татан буулгаж, "Хот тохижилт" компани боягон нэгтгэн зохион байгуулсугай.

Гурав. Бүтцийн өөрчлөлт хийсэнтэй холбогдуулан н.Эрдэнэбаатарыг Ус сувгийн ашиглалтын газрын, н.Жаргалсайханыг Орон сууц, нийтийн аж ахуйн компанийн, н.Нямдавааг Хотын тээвэр зохицуулалтын газрын, н.Дагийсүрэнг Иргэдэд үйлчлэх "Буян" компанийн, н.Даваажавыг Max тос бэлтгэлийн компанийн, н.Бүрэнтогтохыг Гадаадын иргэдэд үйлчлэх "Гэгээ" компанийн, н.Идэрборгилыг Хотын мал эмнэлгийн газрын, н.Нарангэрэлийг "Зураг төслийн товчооны", н.Баатарыг Геодезийн үйлчилгээ компанийн, н.Шаравсамбууг Улаанбаатар импэкс компанийн, н.Ганхуягийг Түлшний мод бэлтгэл компанийн, н.Поолойг Халаалтын зуухны ашиглалтын төвийн, н.Лхамсүрэнг Гэрэлтүүлэг чимэглэл компанийн, н.Магсаржавыг "Цэцэрлэгжилт" компанийн, н.Даяндоржийг "Нөөц" компанийн, н.Отгонсүрэнг "Тохижилт" компанийн дарга, захирлын үүрэгт ажлаас 1997 оны 6 дугаар сарын 14-нээр тасалбар болгон тус тус чөлөөлсүгэй.

Дөрөв. Засгийн газрын 1997 оны 108 дугаар тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд дараах байгууллагуудын дарга, захирлуудыг 1997 оны 6 дугаар сарын 16-наас эхлэн тус тус томилон ажиллуулсугай.
Үүнд:

Осорын Эрдэнюбаатарыг Ус сувгийн ашиглалтын газрын, Намсрайн Нямдавааг Хотын тээвэр зохицуулалтын газрын, Санзайн Бямбасүхийг Орон сууц, нийтийн аж ахуйн компанийн, Цэндийн Идэрборгилыг Хотын мал эмнэлгийн газрын, Содномжамцын Дагийсүрэнг Иргэдэд үйлчлэх "Буян" компанийн, Гомбожавын Даваажавыг Мах, тос бэлтгэлийн компанийн, Шаравдоржийн Тэмэрбаатарыг "Хот тохижилт" компанийн, Хайнжамцын Бүрэнтогтохыг Гадаадын иргэдэд үйлчлэх "Гэгээ" компанийн, Готовын Наангэрэлийг "Зураг төсөл" компанийн, Паламдоогийн Баатарыг Геодезийн үйлчилгээ компанийн, Бадрахын Шаравсамбууг "Улаанбаатар импэкс" компанийн, Найжааны Самбараазаныг Түлшний мод бэлтгэх компанийн, Дэлгэрийн Поолойг Халаалтын зуухны ашиглалтын төвийн даргаар.

Тав. Захирагчийн ажлын алба (н.Гомбожав)-нд даалгах нь:

а/ Газар, компаниудын дүрэм, дотоод журмыг шинэчлэн боловсруулж, зохион байгуулалтын асуудлыг б дугаар сард баатар хийж, хяналт тавьж ажиллах.

б/ ОСНАА, Тохижилт, Түлшний мод бэлтгэх компаниудын захирлуудын ажлыг хүлээлцүүлэх комисс томилж ажиллуулах.

Зургаа.

а/ "Миний Өргөө" компанийн эрхлэх ажил үүрэг, Газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн албанц шилжиж байгаатай холбогдуулан тус компанийг 1997 оны б дугаар сарын 14-нөөр тасалбар болгон татан буулгасугай.

б/ "Миний өргөө" компанийн үндсэн хөрөнгийг Газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн албанц балансаас балансад шилжүүлсүгэй.

Долоо. Зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Улаанбаатар-Ус компанийг 1997 оны б дугаар сарын 14-нөөс эхлэн хотын Ус сувгийн ашиглалтын газрын харьяданд шилжүүлсүтэй.

Найм. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1990 оны Б/212, Б/85, 1992 оны Б/04, Б/128, Б/210, 1995 оны А/37, 1997 оны Б/74 тоот захирамжийн 2, 3 дугаар заалт, Б/86 тоот захирамжийн 2, 3 дугаар заалт, А/18 тоот захирамжийн 2-ын н.Нямдавааг томилсон заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.наанцаац Ж.НААНЦАЦРАЛТ